



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН С.ЦЭНГҮҮН ТАНАА

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ
МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА
АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

Улаанбаатар хот, 17011, Хан-Уул дүүрэг, 15-р хороо,
М.Гандигийн гудамж, МҮХАҮТ-ын байр, УБ шуудан -101011001,
Утас: 77277070, Факс: 976-11-324620,
E-mail: chamber@mongolchamber.mn

2025.12.11 № 01/1131
танай 2025.11.19-ны № УИХ-03/13204-Т

Санал хүргүүлэх тухай

Энэ өдрийн амрыг эрье. Таны санаачлан боловсруулж буй “БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл”, холбогдох бичиг баримт бүхий УИХ-03/13204 тоот албан бичгийг 2025 оны 11-р сарын 25-ны өдөр хүлээн авч танилцлаа.

МҮХАҮТ-ын зүгээс хуулийн төслийн үзэл баримтлал, судалгааны хүрээнд БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болгохыг зарчмын хувьд дэмжиж байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор өөрчлөлт орж буй дагалдах хууль болох “Онц байдлын тухай хууль”-д саналаа хавсралтаар хүргүүлж байна.

Хуулийн төсөлд өгсөн саналуудыг судлан үзэж, тусгахыг хүсье.

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ЛХАГВАЖАВ

0000218

№	Төсөлд тусгагдсан заалт	Өөрчлөх санал	Үндэслэл
1	“16.2.4. шаардлагатай гэж үзвэл төрийн өмчийн болон төрийн өмч давамгайлсан аж ахуйн нэгж, байгууллагын зохион байгуулалтын бүтэц, үүрэг, хөдөлмөрийн норм, цалин хөлсийг шинэчлэн тогтоох, үйлдвэрлэлийн зориулалт, технологийн горимыг өөрчлөх, онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан эрх бүхий албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг зохих ёсоор биелүүлээгүй бүх шатны удирдах ажилтныг онц байдлын хугацаагаар түдгэлзүүлж, орны хүнийг томилох”	“16.2.4. төрийн өмчийн болон төрийн өмч давамгайлсан аж ахуйн нэгж, байгууллагын зохион байгуулалтын бүтэц, үүрэг, хөдөлмөрийн норм, цалин хөлс үйлдвэрлэлийн зориулалт, технологийн горим нь тусгай дэглэмийг хэрэгжүүлэхэд тохиромжгүй, саад болохуйц бол өөрчлөх, онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан эрх бүхий албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй бүх шатны удирдах ажилтныг онц байдлын хугацаагаар түдгэлзүүлж, орны хүнийг томилох”	“шаардлагатай гэж үзвэл”, “зохих ёсоор” гэх нэр томъёоноос аль болох зайлсхийхгүй бол эрх бүхий этгээдийн үзэмжээр шийдвэрлэгдэх магадлалыг өндөр болгодог. Хуулийн нэг зорилго нь хэн нэгний дураар аашлах боломжийг хязгаарлахад оршдог тул эрх мэдлээ хэрэгжүүлэх хэмжээ, хязгаар, үндэслэлийг тодорхой байлгах шаардлагатай.
2	“16.2.7. онц байдлын хугацаанд ажилчин, албан хаагчийг нөхөх олговортойгоор илүү цагаар ажиллуулах”	“16.2.7. онц байдлын хугацаанд ажилчин, албан хаагчийг нөхөх олговортойгоор илүү цагаар ажиллуулах ба энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 84.4-т заасан долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаарыг 1.5 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй байна.”	Онцгой дэглэмийн хугацаанд ч мөн хөдөлмөрлөх, хөдөлмөрлүүлэх эрхийн харилцаа явагдах тул Хөдөлмөрийн тухай хуульд заасан хэмжээг аль хэр хүрээнд хэтрүүлэх боломжтой гэдгийг тогтоож өгөх шаардлагатай.
№	Хуулийн одоогийн заалт	Өөрчлөх санал	Үндэслэл
1	9.4.Онц байдал тогтоосон нутаг дэвсгэрт байгаа төр, нам, олон нийт, хоршооллын төв, орон нутгийн байгууллага, аж ахуйн нэгж,албан тушаалтан,	“хэлбэрэлтгүй” гэдэг үгийг хасах	МУ-ын Засгийн газрын 2016 оны 1-р сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59-р тогтоолын Хавсралт 2-ын 3.1 дэх хэсэгт “...Хуулийн төслийн хэллэгийг

	иргэд онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлж байгаа төрийн байгууллага, албан тушаалтанд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлж, гаргасан шийдвэр, өгсөн үүрэг даалгаврыг хэлбэрэлтгүй биелүүлэх үүрэгтэй.		яруу, төгс төгөлдөр болгох зорилгоор хүч оруулсан нэр томьёо хэрэглэхээс зайлсхийнэ...” гэж заасан байдаг.
2	10.1.5/онц байдал тогтоосон шийдвэр, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Зөвлөл, Засаг даргаас өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлээгүй төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдах албан тушаалтныг огцруулж, орны хүнийг онц байдлын хугацаагаар томилох;	10.1.5/онц байдал тогтоосон шийдвэр, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Зөвлөл, Засаг даргаас өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлээгүй төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдах албан тушаалтныг онц байдлын хугацаагаар түдгэлзүүлж , орны хүнийг онц байдлын хугацаагаар томилох;	Хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн 2-р зүйлд заасны дагуу хуулийн 16.2.4 дэх хэсэгт орж буй өөрчлөлт нь ижил зорилго, утга бүхий заалтад мөн адил үйлчлэх ёстой. Тухайлбал, 16.2.4-т албан тушаалтныг түдгэлзүүлж байхад хуулийн 10.1.5-т ижил үндэслэлтэй атал албан тушаалтныг огцруулж болохгүй. Огцруулах гэдэг үг нь онц байдлын дараа ч ажлаа хийх боломжгүй болгох утгатай байна.
3	15 дугаар зүйл. Онц байдал үргэлжлэх хугацаанд цаазаар авах ял гүйцэтгэхгүй байх Онц байдал үргэлжлэх хугацаанд үйлдсэн гэмт хэрэгтээ цаазаар авах ял шийтгэгдсэн хүний ялыг онц байдал үргэлжлэх хугацаанд болон онц байдал дуусгавар болсон, онц байдлыг цуцалснаас хойшхи 30 хоногт гүйцэтгэж болохгүй.	Хасах	МУ-д хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулинд “цаазаар авах” ялын төрөл байхгүй болно.